



ÃÊ Î ÁÈ Í ÒǺĐÍ ÝØ Í Ë ÒÁÁ

Yí yóꝛꝛ ñí íé àè-àèéá “ǵé áí àèí èyððòèéyð
yðð ÷è° íèè ǵð-èèéí í íèð íðéí áà òàðààð
àón òyáèyè í yáyýèèéí yððéá àyí æ èð íü”
ð° ñèéí òꝛðýyí á “Àèí á Èíð àðíyð íè” QÁ-ààn
2 ñàð ò òò àì á yððéví ààðàí à.

Yí yǎoǎààǎò

Ōàí ä ñî í èđóóóěàòàä
Ōýâëýěèéí ýđ ð ÷° ě°° ã ç° đ÷è ã÷ î đí óóä

Ççí º ì ° ä Åçèéí îđí óóäü í õýâëýèèéí ýðð
÷° ě ° ° í è é òàèĚăĩ

Ōi , đăóăààđ í ċċđ

^a â^o ã ê é í æ î ð
Í è é ò ë ý è é í æ à ì ñ í

Nyōāē ē ēē, īēī ī ēēōōē ōāēēōāō
 (Ī ē-Ād), ōāēēā : ī ēēōēyā āīēī yēāāāōāē ōāē
 Āōōāā, ā°ō° āā:āyō ēēē

Ōóö÷ ç° âë° æ áàéí à
İ yāyō ýðð, ì yāýýëëéí ýðð ÷° ë°°
Òàããóãààð í ççð

Q̄yā n̄ī ēī ū ò óòàé
N̄ī ēī ū ǀǀǃyā
/ǂyē òē ēī n̄ī ēī óóāū í ǃī ēáí í/
Còǃǃāǃóǃǃāǃǃ í ǀǀǃ

a ° ðeéã° çí ðèòóóèàð í ü
 Ðææí, ðæææç, mí èí öýæýèéí ææèòí óóäü í
 ì ° ðã° ð , ñ çéí êîä / Ø áää öéñ
 Äí ëäóáààð í ; ; ð

Äàèàëü äõñàè
Ŏyâëýé ì yáyýëýé äóðàâääã÷ äð°í öèéí
õ° äæèèéí ò° è°°

Öàãàà ççé çî òè ñòî é çî òè öóóè àð 10 àðãà
Í àèì áóãààð í ççð

Сонин бичгийг онлайн болон хэвлэмэл хэлбэрээр авч унших сонирхолтой хүмүүс дараах хаягаар холбоо барина уу.

Манай хаяг: Соёлын төв өргөө, Г корпус,
3 давхар. Улаанбаатар 210620-А. Ш/х-28

Утас: **Э-шуудан**
324627 *globe@magicnet.mn*
324764 *globe@globeinter.org.mn*
99276253 *garav@globeinter.org.mn*
bayan@magicnet.mn

Редакцийн зөвлөл:

- Д.Мөнхбүрэн
- Г.Нарангарав
- Х.Цэвлээ

Òª ÑĚÈÉÍ ß ÂÖÛ Í ÒÀĚÀÀĐÕ Ì ÝÄÝÝĚÝĚ

[illegible]

Ýí ý îí û 5,6 ñàðä á;ñèéí ì îí èòì ð÷âîî ñ ò;ëýýí àâñáí ø óóððàé ì ýáýý

Ñýòã¿¿ë÷àèéí ì ýäýýëýê îëæ àâàõ ýðõèéã çºð÷èâ

[illegible]

Äýäýöýí ã; éã: <http://www.globeinter.org.mn/newsdetail.php?id=278>

Đàăêî ãèéí ñóðâàëæëã÷èä í ýâòðýò ýðð î ëãĩĩĩ í ã;é

[illegible]

Äýēäýōýĩ ã; ēã: <http://www.globeinter.org.mn/newsdetail.php?id=272>

Ñyòã¿;ë÷:èéí ýðõ, Õì Õ-èéí °ì ÷ õ°ð°íã° õàèäëääää° ðõñ°ð áàéí à

[illegible]

Äýëäýðýí ãç éã: <http://www.globeinter.org.mn/newsdetail.php?nid=253>

Ñyôãç;ë÷äèéí ì ýðãýæèèéí çéë àæèëëàããái ä ñààä ó÷ðóóëää

[illegible]

Äyëäyöyí ä; éä: <http://www.globeinter.org.mn/newsdetail.php?nid=256>

“Ãĕî á Èí òǎđí ýø í ě” ÒÁÁ ñàí àà÷ĕ àã÷ăũ í á;ĕýǎò àæèĕĕàæ ááéí à

Oón aáeáóóeéaáa Áeáaí è, Áí eááð, Á¿ðæ, Èaçaðnoái, Í ði ñ, Í íeüø cyðyaí ðí ðí ðyáeyé í yáyyeééí ñæááðð, ¿é ææeéæááá yáóóeááá OAA-ðæ ðaí ððáí Oýáeyé í yáyyeééí ð°ææééí ð°e°° Áaðí -Açéí Á¿nèéí Oí ðoí ç ðeíí aáeáóóeáð Nái aá-eáa-eéí áááð ææeéæá yóýá. 2006 íí ð-ð ñaðúí 11-í á Á¿nèéí í eíneyé Oðeéñe oí ðí áí eñíí Nái aá-eáa-úí ðoðeçáaá ðoñ aáeáóóeéaáúí yðá¿í O.Í aðáí æaðáæe í ðí eí ðí á eðéýí. Á¿nèéí Oí ðoí ðí á 2007 í í á Oðeééí Noái áóe oí ðí íí ç ðeíí aáeáóóeáðað ñaí aá-eáa-aúí ðoðeáañø eéááyðeýáýý. Yí yáðáð ðyí æýýí ðí 2005 í í Èí ðaíí eéí í eíneyé Áí í áí oí ðí íí áí eñíí Oýáeyé í yáyyeééí ð°ææééí ð°e°° Áyeðeéí Oí ðoí ðí ç ðáyeææýé þ í. Áyeðeéí Oí ðoí á 97 í ðí ðí íí 425 ð°e°° e°° a-í ðí eí ðí æ ðyáeyé í yáyyeéééá ð°æ¿¿éýð í eíí ðæð ãñoóáéü á° ða í ð; ðýýðø ðéýeñeíí æéýý.

Äýëãýðýí ã¿ éã: www.gfmd.org



Танд сонирхуулахад

ХЭВЛЭЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨГ ЗӨРЧИЛӨРНӨЙГ

Олон улсын сэтгүүлчдийг хамгаалах хороо болон “Фридом Хауз” байгууллагын саяхан гаргасан шинэ илтгэлээс үзэхэд Умард Солонгос, Мьянма, Ливи, Эквадорын Гвиней болон Беларусь зэрэг улс хэвлэлийн эрх чөлөөг хамгийн их зөрчдөг байна.

Эдгээр орнуудад хараат бус хэвлэл мэдээлэл бараг байхгүйтэй адил бөгөөд тэд амь залгах төдий үйл ажиллагаагаа явуулдаг тухай тус байгууллагын “Хэвлэлийн эрх чөлөө 2006” илтгэлд дурдсан байна.

“Эдгээр орнуудад хэвлэл мэдээлэл тухайн оронд тогтсон дэглэм, эрх баригчдын дуу хоолой болон үйлчилдэг бөгөөд иргэдийн үнэн зөв мэдээлэл авах эрх хязгаарлагдмал байдаг” тухай “Фридом Хауз” цохон тэмдэглэжээ.

Тус байгууллага жил тутмын илтгэлдээ улс орнуудыг хэвлэлийн эрх чөлөөний байдлаар “Чөлө чөлөөтэй”, “Эрх чөлөөгүй” гэж ангилдаг. “Фридом Хауз” байгууллага тухайн улс орны хэвлэл мэдээллийн эрх зүйн орчин, мэдээлэл хүртэх, нийтэлж нэвтрүүлэхэд улс төрийн нөлөө байгаа эсэх, мэдээллийн агуулга болон тараан түгээхэд эдийн

засгийн дарамт шахалт байгаа эсэх шалгуураар тухайн оронд хэвлэлийн эрх чөлөө ямар түвшинд байгааг тодорхойлдог байна. Энэ судалгаанд улс орон болгоны интернэтээр үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг мөн үнэлдэг.

Латин Америк болон Карибийн тэнгис орчмын орнуудад Хэвлэлийн эрх чөлөө сүүлийн 15 жилд эрс буурч байгаад Фридом Хауз түгшиж байна. Тус бүс нутагт “Хэвлэлийн эрх чөлөө”-тэй гэгдэх орны тоо 1990 онд 23 байсан бол 2005 онд 17 болж буурчээ.

Хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан улс орнуудад Хэвлэлийн эрх чөлөөгүй орны тоо 1995 онд долоо байсан бол 2005 онд 10 болж нэмэгдсэн байна.

Сэтгүүлчдийг хамгаалах хорооны “Хамгийн их цензуртэй 10 орон” илтгэлд дэлхийн улс орны сэтгүүлчдэд тулгарч байгаа хамгийн ноцтой аюул нь төрийн санхүүжилттэй цензур юм гэжээ.



Зүүн өмнөд Азийн орнуудын хэвлэлийн эрх чөлөөний тайлан / IFJ 2005-2006/

Төрийн бодлого, хуулиар хэвлэл мэдээлэлд дарамт үзүүлэх

Хэвлэл мэдээлэл нь шууд халдлагад өртөөд зогсохгүй үг хэлэх эрх чөлөөг боомилсон төрийн бодлогын өөрчлөлтийн улмаас хурцадмал байдалд хүрчээ. Зүүн өмнөд Азийн орнуудын засгийн газар хэвлэлийн эрх чөлөөг нухчин дарах оролдлогыг өөгшүүлэх зорилгоор хэвлэл мэдээлэлд тавих хяналт, хууль тогтоомжоо чангалсаар байна.

Афганистан

Афганистанд сүүлийн 12 сар хэвлэлийн эрх чөлөөний байдал сайжирсан ч сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнууд хүнд бэрхшээлтэй тулгарсаар байна.




Афганистанд ОНМХ-ийн шинэ хууль батлагдаж, хэвлэлийн эрх чөлөөг бичгээр баталгаажуулан, сэтгүүлчид засгийн газраа шүүмжлэх эрхтэй болсон ч айлган сүрдүүлэх, хэвлэл мэдээллийн дуу хоолойг боох оролдлого үргэлжилж байна. Өнгөрсөн жил 4 сэтгүүлч ажил үүргээ гүйцэтгэж яваад амиа алджээ.

Бутан

Бутанд хэвлэл мэдээлэлтэй холбоотой хууль, дүрэм байхгүй. Тэгэхээр хэвлэлийн эрх чөлөө ч байхгүй гэсэн үг. Засгийн газрын түшмэд хэвлэж нийтлэх, өргөн нэвтрүүлгээр цацах мэдээнд цензур тавьдаг. Засгийн газар хувь хүмүүсийн хэвлэн нийтлэх урам зоригийг мохоогоод зогсохгүй хүнд шийтгэл ногдуулж байна.

Тус улсын иргэний харьяатын тухай хуульд “Хаант засаглалын эсрэг үг хэлэх зэргээр хааны эсрэг үйл ажиллагаа явуулсан, ийм үйл ажиллагаанд оролцсон хэнийг ч болов тус улсын иргэн байх эрхийг нь хасна” гэж заажээ.



Тус улс 1999 оноос гадаадын телевизийн суваг хүлээж авч, интернэт ашиглах боломжтой болсон ч Энэтхэгийн мэдээ, телевизийн цэнгээнт нэвтрүүлгийн сувгийг 2005 оны наймдугаар сард дахин хаасан байна. Хэдийгээр тус улсын

Үндэсний Ассемблейн дүрэмд “Үндэсний Ассамблейн гишүүн нь ассамблейд үзэл бодлоо илэрхийлэх онцгой бүрэн эрхтэй. Гишүүний үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд ямар ч хуулиар халдаж болохгүй” гэж заасан байдаг ч хэвлэлийн эрх чөлөөг хязгаарласан хэд хэдэн заалт байдаг.

Балба

Балбад төрийн эргэлт гарсны дараа тогтоосон онц байдлыг олон улсын шахалтаар 2005 оны 4-р сарын 29-нд цуцалсан байна. Гэвч Засгийн газар чөлөөтэй хэвлэж, нийтлэхийг хэвлэл, мэдээллийн хэрэгслүүдэд зөвшөөрөхгүй хэвээр байна. Хаан ширээнд залрахаас өмнө ч хэвлэлийн эрх чөлөө ийм байдалтай байсан юм. Онц байдлыг цуцалснаас хойш гурав хоногийн дараа буюу 2005 оны 5-р сарын 2-нд Бүс нутгийн захирагч Рабиндра Чакрабарти Мэдээлэл, Харилцаа холбооны яамны 2005 оны 2-р сарын 2-нд гаргасан мэдэгдлийн дагуу FM станцууд зөвхөн “цэнгээнт” нэвтрүүлэг цацах захирамж гаргажээ. Бүс нутгийн захирагч ийм захирамж гаргах эрх мэдэлгүй тул түүний энэ алхам нь хууль бус бөгөөд Дээд шүүхийн шийдвэрийг зөрчсөн байна.

Балбын Хааны Арми /БХА/-ийн шахалтаар Засгийн газар 2005 оны 5-р сарын 27-нд “Коммуникэйшн Корнёр” компанид мэдэгдэл өгөн тайлбар хийх боломж олголгүй, компаний үйл ажиллагааг шууд зогсоожээ. Компани давж заалдсан ч Дээд шүүх Засгийн газрын шийдвэрийг хэвээр үлдээсэн байна.

Террорист болон Хорлон сүйтгэх үйл ажиллагааг таслан зогсоох тухай хуульд 2005 оны 4-р сарын 11-нд нэмэлт оруулжээ. Энэ нэмэлтээр Маог дэмжигчдэд мэдээлэл түгээх, хүлээн авах тохиолдлыг “терроризм болон хорлон сүйтгэх үйл ажиллагаатай холбоотой гэмт хэрэг” гэж үзэх болсон төдийгүй үүнд буруутай нь н о т л о г д с о н хүмүүсийг 10 мянгаас 50 мянган рупи /150-700 доллар/-оор торгох буюу 1-3 жил шоронд хорих ял оноох болжээ.

Бэлтгэсэн:

Г.Нарангарав



(Түрүүч № 3)

Өвөөгийн жор _____

Нийтлэлийн жам ёсон

Соёлын гавьяат зүтгэлтэн
Хорлоогийн ЦЭВЭЛЭЭ

8. "Түүний нэрийг дуулж сонсоогүй хүн ховор. Монголчуудын олонх нь харин түүний тухай "Москваг шатаасан хаан" гэхээс өөрөөр бараг мэдэхгүй. Тэгвэл Наполеон Бонапарт гэж хэн юм бэ?"

Наполеон бол бахархалтай бас эмгэнэлтэй хувь заяатай нэгэн. Эрх мэдэл, алдар хүндийн төлөө тэр амаргүй зам туулж, уулын бэлээс оргилд гарч, тасралтгүй 22 жилийн турш францын төрийн жолоог атгаж, түүхийн хүрдийг эргүүлэлцсэн ч амьд сэрүүн ахуйдаа олсон бүхнээ алдсан юм. Тэр Европын францыг Дэлхийн франц болгосон гавьяатны нэг. "Цэрэг хувцас өмссөн бүхэн Чингис хаанаас суралцах ёстой" гэж номлодог байсан цэргийн нэрт жанжин Наполеон Бонапарт дэлхийн түүхэнд нэрээ мөнхөлсөн жанжин юм." (С.Жамбалдорж, Э.Сонинтогос. "Гайхамшигт Франц орон")

Харав уу. Авьяаслаг сэтгүүлчийн тархи толгой ийнхүү ерийн юмсыг энгийн атлаа ер бишээр сэтгэж бас бусдын хэлээгүйгээр хэлж чаддаг байх юм. Намайг арай өөр өнцгөөс анзаарч нэг хараадахаач, хэлээгүйгээр хэлээд, уран гоёор бичээд өгөөч гэх шиг цаглашгүй аугаа мөртлөө машид энгийн амьдрал аальгүйтэн дууднам бус уу.

Нийтлэлийн зохиомж аль хэр сайн болсныг ажиглаж үнэлэх нь өөрийн бичсэнийг өөлж шилэх эхний чухал алхам мөн. Зохиомж гэж нийтлэлийн зохион байгуулалтын бүтцийг хэлнэ. Зохиомжийг гарчиг, эхлэл, үндсэн нийтлэл, төгсгөл гэж бүдүүвчлэн хуваана.

Гарчиг. Нийтлэлийн технологид гарчиг их үүрэгтэй. Гарчиг нь "Их говийн зоригтон хүмүүс", "Өвлийн нүүдэл", "Нью Йорк урт цацтай хот", "Далай ээж цаазын тавцанд", "Авьса тэтгэвэрт гардаггүй", "Эх орны ногоон хүрэм сэлгэгдэж байна", "Дэглэгчдэд дэг хэрэгтэй", "Мөнхийн бүтээл мөхлийн ирмэгт" гэдэг шиг доторх агуулгаа бүрэн илтгэсэн, бас хэдэн жилийн дараа ч хүний санаанаас гарахааргүй тогтоц сайтай байх учиртайг бодож үнэлгээ өгөх хэрэгтэй.

Өөрийнхөө зовж зүдэрч бичсэн нийтлэлийн бүтээлийг (ярилцлага ч бас өөрийн оюуны бүтээл тул) хэн нэгэн хүний хэлсэн зуурдын үгнээс ишлэн авсан үгээр гарчиглах нь чухамдаа бол тэнэг хэрэг. Нийтлэл бол том бага гэхгүй эцсийн хариуцлагыг нь өөрөө хүлээж байгаа оюуны бүтээл учраас эхэндээ оносон гарчигтай, төгсгөлд нь өөрийн нэр хаягийг бичихэд сэтгэл бүрэн ханамжтай байх учиртай.

Эхлэл. Бичлэгийн технологийн нэг чухал хэсэг нь эхлэл. Эхлэл нь уншигчийг хөтлөх бурантаг эсвэл улаач, замчин гэж ойлгоход болно. Нийтлэлийн практикаас харахад залуу сурвалжлагч нар нийтлэлийнхээ эхлэл дээр алдах нь их байдаг. Эхлэлийн ач тусыг дутуу ухаардгийнх биз.

Эхлэл муутай нийтлэл уншигдахгүй. Уншигдахгүй бол түүнийг бичихийн хэрэг байхгүй. Тэгэхээр нэгэнт бичиж байгаа бол сайн эхлэл сонгож олох хэрэгтэй. Эхлэлийг нийтлэлийн түлхүүр гэж бодвол зохилтой. Нийтлэлийн эхлэлд тактикийн гэмээр хувилбар байдаг. Тэр нь өгүүлэх гэж байгаа үндсэн санаа, гол агуулгыг чухам хаана байрлуулж танилцуулахыг хэлж байна. Эхлэл нь оновчгүй болсон бол үндсэн санаагаа хэлж амжаагүй байхад уншигч маань нэг бол унтаад өгнө, эсвэл өөр нийтлэл рүү яваад өгнө. Амандаа орсон шар тосыг хэлээрээ түлхэнэ гэгч тэр болно.

Шууд эхэлж хэлэх, өмнөтгөлтэй хэлэх, санаагаа нууж яваад төгсгөлд нь тайлж хэлэх гэхчлэн янз бүрийн хувилбар байдаг. Уншигчдыг "100 метрийн гүйлт"-ээр ядраах хэрэггүй гэсэн онол бий. Хэт алсаас эхлэхийг 100 метрийн гүйлт гэж хэлдэг.

Үндсэн хэсэг. Үндсэн сэдвээ хэрхэн яаж бичих, ямар зохиомжийн хэлбэр ашиглахыг бичигч хүн өөрөө л мэдэх хэрэгтэй. Хамгийн чухал шаардлага бол дотроо

зөрчилдөөгүй тоо баримт болон нэр томьёоны будлиангүй, чадаж гэмээнэ сонирхолтой хэлбэрээр бичихийг бодсон байх нь зүй.

Төгсгөл. Төгсгөл бас их учир начиртай. Ерөнхийдөө бол үндсэн санаагаа зангидаж, шаардлагатай бол тайлал хийж цаашдын хандлагыг ямар нэг хэмжээгээр төсөөлсөн байх загвар манайд зонхилж байна. Юм бодуулах, идэвхтэй хөдөлгөөний санаа шидэх, урамшуулах маягийн төгсгөл ховор байна. Ямар ч гэсэн хараалын үгээр төгсгөл хийх нь онцгүй. Харин өгөөдөж болно. Хор шарыг нь хөдөлгөсөн хошигнол өгөөдлийн төгсгөл чухал юмны нэг ээ.

Мэдээнээс бусад нийтлэл тусгайлсан төгсгөлтэй байх ёстой. Гэтэл төгсгөлгүй бүр хэтрээд бичсэн эзэн нь тодорхойгүй нийтлэл олширлоо. Өөрийн таашаалаар төгсгөл хийхийг уншигчдаа найдаж үлдээдэг логикийн арга байж болдог. Гэхдээ энэ бол онцгой тохиолдолд хэрэглэдэг арга. Сонголтын арга гэж нэрлэнэ. Уншигчид мэдээллийг өөрийнхөөрөө хүлээн авах эрхийг хүндэтгэдэг бодит сэтгүүл зүйн үндсэн шаардлага нь ийм байдаг. Тийм тийм нэртэй, ийм ийм чанартай төчнөөн төрлийн саван байна, алийг нь сонгож худалдан авахаа Та өөрөө мэдээрэй гэсэнтэй адилавар утгаар логик төгсгөлийг хэрэглэдэг.

Харин соён гэгээрүүлсэн, задлан шинжилсэн нийтлэлд заавал эрэмбэнд оруулсан төгсгөл хэрэгтэй. Төгсгөлгүй нийтлэлийг хариуцлагагүй нийтлэл хэмээн нэрлэхэд утга дүйнэ.

ГУРАВ. Нийтлэлийн дотоод тэнцвэр.

Нийтлэлд технологийн шинжтэй дотоод тэнцвэр байдгийг мартаж болохгүй. Нийтлэл нь эцсийн дүндээ мэдээллийн багц байх учиртай. Түүнд багтсан тэдгээр мэдээллүүд нь өөр хоорондоо тэнцвэртэй байх ёстой нь мэдээж. Ерөнхийдөө хоёр төрлийн тэнцвэрт харилцаа байдаг байна. Нэгд, ерөнхий ба тусгайн тэнцвэр, хоёрт, мэдэх ба мэдэхгүйн тэнцвэр юм. Ерөнхий, тусгай гэдэг нь гүн ухааны хэллэг бөгөөд нийтлэлийн практикт бол дүгнэлт ба баримт гэсэн утгаар бууж ирдэг. Дүгнэлт нь илүүдээд нотлох баримт нь хомсодвол хоосон мэт болдог. Ийм нийтлэлийг бичсэн бичээгүй хоёр нь эцсийн дүндээ адил учраас бичихгүй байх нь төвөг чирэгдэл багатай.

Баримт илүүдэхийн зовлон гэж бас яггүй хэцүү зовлон бий. Нэг баримтаас олон янзын мэдлэг, олон хувилбартай үзэл санаа гарч болдог учраас дүгнэлтээр цэгцрүүлээгүй баримтууд уншигчдын толгойд хумхийн тоос мэт үл танигдах зах замбараагүй ертөнцийг бий болгодог. Баримтаа оношлож танихгүй байгаа бол бичихийн хэрэггүй.

Мэдэх мэдэхгүйн харьцаа гэдэг нь нийтлэлд орж байгаа шинэ ба хуучин мэдээлэл, шинэ ба хуучин үзэл бодлын харьцааг илэрхийлнэ. Шинэ хуучин үзэл бодол гэдэг хэмжигдэхүүн нь даамжирсаар таалагдах ба эс таалагдах үзэл бодол маягаар туйлшран талцахад хүргэдэг муу талтай.

Мэдэх ба эс мэдэхийн харилцааг тэнцүүлэхэд хамгийн чухал чиг баримжаа бол ямар уншигчдад зориулан нийтэлж байгааг анзаарч тэр түвшний онцлогт зохицох нь зөв юм. Мэргэжлийн физикчдэд зориулсан нэр томьёоны хэллэгээр малчдад зориулсан нийтлэл бичээд ашиг гарахгүй. Тэд ойлгохгүй. Өндөр хэмжээний мэдлэгтэй, баруун зүүний ертөнцөд сэлгүүцэж явсаар нүдний ялгаа нь багассан сэхээтнүүдэд мэдээжийн зүйлийг нуруйн тайлбарлахын хэрэггүй. Өндөр настнуудад зориулсан нийтлэл, хүүхдийнхээс өөр өнгө аястай байж таарна. Манай хэвлэл мэдээллийн байгууллагын нэг доголдол нь ийм эрс тэс ялгааг нийтлэлийн бодлогоороо төдийгүй сонин дэглэлтийн урлагтаа тэр бүр тусгахгүй байгаад оршино. Сонины булангууд нь тогтворгүй болсон учраас уншигчид төөрөлдөж байна.

Мэдэхгүй гэдгийн ар талд уншиж сонсоогүй гэсэн утга харгалзан тохирно. Өмнөх мэдлэгийг үл харгалзан дандаа шинэ мэдлэг мэдээллээр нийтлэлийг бүрдүүлэх нь мэдээжээр бичиж байгаа хүндээ тааламжтай сонирхолтой мэт байдаг боловч нийтлэлийг хялбаршуулахын оронд хүндрүүлж уншигчдыг хулжаах гэмтэй. Хүний тархи гэдэг их залхуу. Тиймээс аливаа мэдээллийг хүлээн авахдаа амар хялбар талаас нь хандаж өмнөх мэдлэгийнхээ агуулахад хурааж авах гэж зүтгэдэг. Түүнд нь таарч тохирохгүй байвал буруу эсвэл хортой, худал хуурмаг зүйл гэж итгэж шууд дайснагнх нь элбэг.

Орчин үеийн уншигчид их голомтгой, сонжооч болсон. Сонирхох журмаар гүйлгэн унших хөнгөн хэвшил тогтож дээхнэ үеийн бодож унших, уншаад бодох арга барил ихэд ховорджээ. Мэдээллийн эрин зуунд амьдарч зай завсаргүй олон мэдээлэлд дарагдаж залхаж байгаагийн гэрч биз. Хурд, хүч хоёрыг зэрэг хожиж болдоггүй физикийн хууль мэдээллийн салбарт үйлчилж байгаа нь тэр биз ээ.

Нийтлэл шинэ мэдээллээр ховор, дандаа л мэдээжийн зүйл улиглаж жижүүрийн сэдэвтэй нэгэн хэв маягаар ноцолдохыг “Богшоосон шөлөөр дайлах” гэж нэрлэдэг. Үүндээ ч шинэ сонин мэдээ, шинэ сэрэг мэдлэг хүлээж суугаа уншигчдыг мэдээллийн “Шинэ шөл”-өөр дайлахгүй, бичдэгийгээ л бичээд байх аваас зочноо богшсон шөл халааж дайлахаас юуны өөр билээ. Ийм тоомжиргүй эзнээр дайлуулсан зочны сэтгэл яаж өөдрөг өрнүүн байхав дээ. Шинэ хуучин мэдлэгийн тэнцвэрийг нийтлэлд чухалчилдгийн зарим учир ийм буюу.

ДӨРӨВ. Нийтлэлийн дотоод хяналт.

Тов тодорхой горимоор уншууртай, өгөөжтэй нийтлэл мөн эсэхийг шалгаж үздэг.

Эхний ээлжинд баримтын шалгалт хийнэ. Тэр нь нийтлэлд орсон хүний овог нэр зөв эсэх, он сар хугацаа нь тохирч байгаа эсэх, байгууллага, аймаг, сум, баг, уул усны нэр ташаарсан эсэх, тоо баримт, зүйрлэл, ишлэл магадтай эсэх гэхчлэн олон зүйлийг ажиглан шалгах хэрэгтэй. Нүүр дүүрэн сайхан нийтлэлийг өчүүхэн ганц муу алдаа хүчингүй болгож чаддаг юм. “Үхрийн сүүлэн дээр хутгаа хугалчихгүйн”

тулд эсвэл “Алдыг нь аваад дэлэм дээр нь сөгдчихгүйн” тулд бичигч нь өөрөө сайн шалгасан байх ёстой.

Дараагийн сорил нь хэл бичгийн шалгалт байдаг. Сонин бол улс төрийн баримт бичиг биш, албан бичиг биш гэдгийг анзаарах хэрэгтэй. Хэл бичгийн шалгалтын эхнийх нь **албаны хэллэгээс чөлөөлөх** шалгалт байх шаардлагатай. “Ба, бөгөөд, одоо, мөн, болбол, түүнчлэн, хэрэгтэй, ёстой, гэж үзэж байна, тусламж үзүүлэн, ажил зохионо, тодорхой арга хэмжээ авна” гэж жишээний албархуу хэлбэрийн үлдэгдлээс цэвэрлэсэн эсэхийг хэлж байна.

Хэл бичгийн шалгалтын хоёр дахь алхам нь **гадаад хэлний түрэмгийллээс хамгаалах** шалгалт байж таарна. Их гүрний хэл соёлын түрэмгийллийг жижиг үндэстний жижиг сэхээтнүүд өөрсдөө үйлддэг гэж мэргэд сургасан байдаг юм. Гадаадын үг нэр томьёоллыг нийтлэлээсээ хайр найргүй үлдэн хөөсөн байх шаардлагатай. Нийтийн хэлж хэвшсэн гадаад үгийг хэрэглэх хэрэгцээ гарвал Монгол дуудлагаараа монгол бичгээрээ бичвэл улам сайн.

Монголын хэл соёлын тусгаар тогтнол хийгээд монгол хэлний бие даасан бүрэн эрхийг зөвхөн сэтгүүлчид л бүхнээс түрүүнд амь насаар дэнчин тавьж байгаад ч гэсэн хамгаалах үүрэгтэй.

Эдгээр дотоод хяналтыг хийснийхээ дараа “Ерөнхий” хяналт хийх хэрэгтэй. Юуны тухай ярьж байна вэ гэвэл, уншигчдын ууцыг нь хугалж байна уу? Урмыг нь сэргээж байна уу? гэдгийг цэгнэж үзэхийг хэлж байна. Шүүмжилсэн, сайшаасан, гэгээрүүлсэн ямар ч нийтлэлд тавигддаг түгээмэл шаардлага нь **урам хайрлах** явдал гэж үздэг байна.

Заримдаа хэт их бухимдсанаас болоод дэндүү бараан өнгөтэй болгож шүүмжлэх явдал гардаг. Гэхдээ л дээрэлхэх шарлах, хүний өмнөөс хэн нэгэнд хэлэх хэлэхгүй үг чулуулах ёсгүй л дээ. Яагаад гэвэл сэтгүүл зүй маань өөрөөсөө хүмүүнлэгийн ухаан тул унаган зориулалтаас нь хазайлгах эрх сэтгүүлч гэгдсэн хэнд боловч байх ёсгүй. Хүний амь насыг хохироосон хэрэгтэнд ч хүний л ёсоор хандах ёстой. Тэгэж байж чөлөөт хэвлэл нь хүний эрх, хүний нэр төрийн харуул манаач байх үүргээ биелүүлнэ. Магтаж байгаа нэрээр онгироож, шүүмжлэх далимаар гутаан доромжилсон байх ёсгүй гэдэг үүднээс нийтлэлийг харах хэрэгтэй.

үргэлжлэл дараагийн дугаарт

Сэтгүүл зүй, олон нийттэй харилцах (Пи-Ар), реклам: нийтлэг болон ялгаатай тал

[illegible]

Хүн бүр өөрийн үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрхтэй. Энэхүү эрхэнд үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах, эрх чөлөө, үзэл санаа мэдээллийг улсын хилийн заагаар үл хязгаарлан аливаа арга замаар эрж сурвалжлах, хүлээж авах, түгээн дэлгэрүүлэх эрх чөлөө багтана. /Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал, 19 дүгээр зүйл/

Мэдэх эрх, мэдээллийн эрх чөлөө

Олон нийт хэн нэгэн албан тушаалтныг хардаж сэрдэн “энэ баяжаад байна, хээл хахууль авсан байх” хэмээн үл ойлголцох нөхцөл байдал үүсэхээс хамгаалах хамгийн оновчтой арга, шийдэл нь мэдээллийн нээлттэй, ил тод байдал мөн. Монгол Улсын Үндсэн хууль /МУҮХ/-д Хүний эрх, эрх чөлөө гэсэн хоёрдугаар бүлэг тусгайлан орсон бөгөөд арван зургадугаар зүйлд “Монгол Улсын иргэн дараах үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ” гэжээ. Арван зургадугаар зүйлийн 17 дахь хэсэгт “Төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална” гэжээ.

Монгол Улс бол Нэгдсэн Үндэстний Байгууллага /НҮБ/-ын гишүүн улс. Энэ утгаараа Хүний Эрхийн Түгээмэл тунхаглал /ХЭТТ/-ыг хэдийгээр хууль мэт дагаж мөрдөхгүй ч гэсэн НҮБ-аас түүний бүх заалтыг дагаж мөрдөхийг гишүүн улсууддаа уриалсан байдаг тул ХЭТТ-ыг хүндэтгэн үзэх нь Монгол Улсын үүрэг мөн. ХЭТТ-ын 19 дүгээр зүйлд:

“Хүн бүр өөрийн үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрхтэй: энэхүү эрхэнд үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах, эрх чөлөө, үзэл санаа мэдээллийг улсын хилийн заагаар үл хязгаарлан аливаа арга замаар эрж сурвалжлах, хүлээж авах, түгээн дэлгэрүүлэх эрх чөлөө багтана”.

Иргэний болон Улс Төрийн Эрхийн тухай Олон Улсын пакт /ИУТЭОУП/-ын 19 дүгээр зүйлд:

1. Хүн бүр үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах эрхтэй.
2. Хүн бүр санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй: энэ эрхэнд төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр эсхүл хэвлэлийн буюу уран сайхны аргаар эсхүл өөрийн сонгосон бусад аргаар эрж хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөө багтана.
3. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт дурдсан эрхийг эдлэх нь онцгой үүрэг, хариуцлага оногдуулна. Тийм учраас түүнийг зарим талаар хязгаарлаж болох боловч тэр нь гагцхүү хуулиар тогтоогдсон байх ёстой:
 - а/ бусдын эрх, нэр төрийг хүндэтгэх,
 - б/ үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд буюу ёс суртахууныг хамгаалах”.

ИУТЭОУП-ын болон бусад Олон Улсын гэрээ хэлэлцээрийн хувьд заалтуудыг заавал дагаж мөрдөх ёстой. Учир нь Монгол Улсын Үндсэн хуулийн 10-р зүйлийн 3 дахь хэсэгт Монгол Улсын нэгдэн орсон болон соёрхон баталсан Олон Улсын гэрээ хэлэлцээр нь дотоодын хууль тогтоомжийн ажил үйлчилнэ гэж баталгаажуулсан байдаг.

Эдгээр эрх зүйн хэм хэмжээнүүд нь мэдээллийн нээлттэй ил тод байдлыг баталгаажуулсан зохицуулалт нь юм.

МУҮХ-ийн оршил хэсэгт “Монголын ард түмэн бид ... эх орондоо хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно” гэж заасан нь Монголчууд бүх нийтээрээ ардчиллын төлөө, ардчиллыг

төлөвшүүлэхийн төлөө эрмэлзэх ёстой, мөн бид ардчилсан нийгэмд амьдарч байна гэсэн үг юм. Гэвч ардчилсан нийгэм мөн эсэх нь мэдээллийн эрх чөлөө, хэвлэлийн эрх чөлөө гэсэн ардчиллын нэгэн зарчим, хэмжүүрээр хэмжигддэг билээ. Өөрөөр хэлбэл, үүнийг төр нь ард түмнээсээ хэр зэрэг мэдээллийг нууцалж байгаагаар дүгнэж болно. Дарангуйлагч төр ард түмнээсээ мэдээллийг нууцалж, төр нь ард түмэндээ үйлчилж байхын оронд төр нь ард түмнээ өөртөө үйлчлүүлж, ард түмнээ үг дуугүй өөрийн хүсэл сонирхолд нийцэж байхыг шаарддаг билээ. Ийм дарангуйлагч төр иргэдийнхээ мэдээлэл олж авах эрхийг бүдүүлгээр зөрчин хэвлэл мэдээллийн хэрэгслийг өөрийн цагдан хяналтанд ажиллуулдаг. Ийм учраас иргэд хуурмаг мэдээллийг хүлээн авахаас өөр аргагүй байдаг юм.

Харин ардчилсан нийгэмд цагдан хяналтгүй, чөлөөт, тэнцвэртэй мэдээлэл нь нийгмийн хөгжлийн болон сударга ёс цэцэглэн хөгжих гол хөшүүрэг, амин сүнс нь юм. Ийм учраас НҮБ-ын анхдугаар чуулганы 59 дүгээр тогтоолд “мэдээллийн эрх чөлөө хүний язгуур эрх чөлөө бөгөөд НҮБ-аас эрхэмлэдэг хүний бусад эрхийн тулгын чулуу..., бусад эрх, эрх чөлөөний үндсэн хэмжүүр мөн” гэсэн байдаг.

Мэдээллийг олон нийтэд хүртээмжтэй хүргэх үүргийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сэтгүүлчид хүлээдэг. Тийм учраас олон нийтийн мэдэх эрхийг хангах үүрэгтэй сэтгүүлчид маань ямар нэгэн төрийн байгууллага албан тушаалтнаас мэдээлэл авахдаа “тухайн мэдээлэл нь тэр байгууллага, албан тушаалтны өмч бус харин нийт иргэд, нийт татвар төлөгчдийн өмч” гэсэн утгаар асуудалд хандах ёстой юм. Тухайн байгууллага албан тушаалтан таны авахыг хүссэн мэдээллийг ямар нэгэн нууцад хамаарна хэмээн өгөхөөс татгалзаж болно. Энэ тохиолдолд та урьдчилан Төрийн нууцын тухай хууль болон Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулиудыг судалж чухам ямар асуудлууд төрийн нууцад хамаардаг болохыг мэдсэн байх нь чухал юм. МУҮХ, ХЭТТ, ИУТЭОУП-д зааснаар нууцыг гагцхүү хуулиар тогтоох ёстой бөгөөд хуулиас гадуур нууц гэсэн ойлголт үгүй юм. 1995 онд манай улсад Байгууллагын нууцын тухай хууль батлагдсан. Энэ хуулиар байгууллага өөрийн нууцыг өөрөө тогтооно гэсэн байдаг бөгөөд мөн бүх хүссэн мэдээллээ нууцалж болохгүй тухай бас заасан байдаг. Энэ нь тухайн байгууллагын явуулж буй үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж буй техник, технологийн хүн амын эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийг илтгэн харуулах мэдээлэл, тухайн байгууллагын мэдэлд байгаа бөгөөд хадгалалт, хамгаалалтын горим нь зөрчигдсөн тохиолдолд хүн амын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд аюул учруулж болзошгүй бүх төрлийн хорт, цацраг идэвхт бодисын хор хөнөөлийг тодорхойлсон мэдээлэл, гэмт хэргийн тухай болон нийтэд мэдээлэхээр хуульд заасан бусад мэдээлэл гэсэн хязгаар тогтоожээ. Энэ хуулиар байгууллага өөрийн нууц гэж үзсэн мэдээллээ нууцлахдаа нууцын жагсаалтаа батлах ёстой. Харин хэн ч гэсэн энэ нууцын жагсаалттай нь танилцах эрхтэй байх ёстой юм.



хуульч Г.Даваахүү

Хүн бүр санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй. Энэ эрхэнд төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр эсхүл хэвлэлийн буюу уран сайхны аргаар, эсхүл өөрийн сонгосон бусад аргаар эрж хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөө багтана. /Иргэний болон Улс төрийн эрхийн тухай Олон Улсын Пакт, 19 дүгээр зүйл/

Тэд сонины тухай

Сонины үүрэг /Дэлхийн Сонинуудын Холбоо/

Дэлхийн сонины өндөр албан тушаалтнууд сонины нийгэмд гүйцэтгэх үүрэг, бусад өрсөлдөгч мэдээллийн хэрэгслээс ямар ялгаатай болох, сонины давуу тал, сонин хэтэрхий популист чиг хандлагатай болж байгаа тухайд, мөн сонины борлуулалт, нөлөөг нэмэгдүүлэхэд ямар арга хэмжээ авах зэрэгт өөрсдийн байр сууриа илэрхийлжээ.

1. Нийгэмд гүйцэтгэх үүрэг

Солонгосын хэдэн арван үндэсний сонин дунд "Жун Ан Илбо" сонин онцгой үүрэг гүйцэтгэдэг. Солонгост 100 жилийн тэртээ өрнөдийн соёл нэвтрэх үед сонинууд нь нийгэмд сурган хүмүүжүүлэх үүрэг гүйцэтгэж байлаа. Харин ард түмэн тусгаар тогтнолынхоо төлөө тэмцэж, өөрчлөлт шинэчлэлт хийн ардчилсан нийгэмд шилжиж байх үед Солонгосын сонинууд ард түмэнд чиглүү лэгч болж байв. Энэ нь Солонгосын сонинуудын уламжлал болон тогтжээ. Сэхээтэн, нийгмийн дээд давхаргынхны уншдаг сонин болохын тулд "Жун Ан Илбо" нийгмийн дэвшилтэт зүйлсийг хөхүүлэхэд ихээхэн анхаарч иржээ. Хүмүүсээс нэг алхам түрүүнд явахын тулд тус сонин нийгмийг хамарсан, анхаарал татсан асуудал, тэдгээрийг шийдвэрлэх арга замын талаар хөндөн нийтэлдэг. Энэ нь тус сонины хамгийн гол зорилтын нэг юм.

Коммунизмыг байгуулахын төлөө болон коммунизмын эсрэг үзэл суртлын хооронд хагас зуун жил үргэлжилж байгаа мөргөлдөөний цаг үед Солонгосын сонинуудын олонхи консерватив урсгалыг дагаж байв. Коммунизмын эсрэг үзэл суртал консерватив урсгал нь ижил мөн чанартай юм. 1980-аад оны сүүлчээс л зарим жижиг сонинууд Солонгосын сонинуудын уламжлалт консерватив урсгалаас ангижирч эхэлжээ. Консерватив үзэл баримтлалтайд тооцогдож байсан "Жун Ан Илбо" сонин уламжлалт, хэт их хуучинсаг үзэл баримтлалаас зайгаа барьж, Солонгосын нийгмийн шинэ сорил, шинэ орчинд дасан зохицох болжээ. Тус сонин хараат бус, нээлттэй байхыг эрмэлзэх болсон байна. Сонины үзэл бодлоо илэрхийлэх хуудсанд маргаан зөрчилтэй ч бай ямар ч үзэл бодлыг илэрхийлэх нь нээлттэй байдаг. Тус сонин улс төрийн болон үзэл баримтлалын хувьд төвийг сахисан, хараат бус нийтлэлээрээ олон түмэнд үнэлэгддэг учир энэ байр сууриа хадгалдаг. Умард-Өмнөд Солонгосын хямралын тухайд хоёр Солонгосын эв нэгдэл, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд гаргаж буй "Жун Ан Илбо" сонины цуцашгүй хүчин чармайлт ахицтай байна.



2. Бусад хэвлэлтэй харьцуулахад

Солонгост интернет, өргөн нэвтрүүлэг, тэр дундаа телевиз нь сонины хамгийн гол өрсөлдөгч болж байна. Зар сурталчилгааны зах зээлд телевиз нь сонин, сэтгүүлийг давамгайлдаг. Өргөн нэвтрүүлгийн хэрэгслийг бодвол сонин нийгэмд онцгой үүрэг гүйцэтгэсэн хэвээрээ, нөлөө нь буураагүй байна.

Солонгосын өргөн нэвтрүүлгийн хэрэгслүүд эзэмшлийн байдал, хуулийн зохицуулалтаас хамааран улс төрийн хувьд хараат бус байж чаддаггүй. Тиймээс хүмүүс сониноос үнэн зөв, бодитой мэдээллийг авдаг. Дээр дурдсан хязгаарлалтын улмаас өргөн нэвтрүүлгийн мэдээллийн хэрэгсэл асуудлын



мөн чанарыг олж тогтоосон, задлан шинжилгээ хийсэн мэдээ нийтлэл дамжуулах бололцоогүй аж. Өргөн нэвтрүүлгийн хэрэгсэл үзэгчдийн анхаарлыг удаан хугацаанд тогтоон барьж чаддаггүй. Өргөн нэвтрүүлгийн ач холбогдол бага, сэтгэл хөдлөлд тулгуурласан мэдээ нь үзэгчдэд нөлөөлж, тэдний зүрх сэтгэлийг эзэмдэж чадахгүй байна. Харин спорт, хөгжим гэх мэт

цэнгээнт нэвтрүүлгийн хувьд сонин нь телевиз, радиотой өрсөлдөх аргагүй юм. Тэгэхээр сонинууд юмыг эргэцүүлэн бодох дуртай, асуудлын мөн чанарыг задлан шинжилсэн мэдээ материалыг илүүд үздэг уншигчдаа авч үлдэхэд илүүтэй анхаарах хэрэгтэй байна.

3. Сонины давуу тал

Уншигчийн итгэлийг үл алдах найдвартай чанар нь сонины жинхэнэ баялаг юм. Мэдээгээр хахсан интернетэд худал хуурмаг мэдээлэл үнэн бодит мэдээллийг ялгаж салгах аргагүй байдаг. Өргөн нэвтрүүлгийн хэрэгсэл чухал мэдээллийг хурдан дамжуулдаг давуу талтай ч үзэгчид дэлгэцээр гарсан дүрсийн найдвартай эсэхийг бүрэн дүүрэн шүүж чаддаггүй. Харин сонин уншигчдад тухайн асуудлын учир шалтгааныг олж, логиктой бодож тунгаах бололцоо олддог. Хэвлэл мэдээллийн бусад хэрэгслийн дамжуулж байгаа мэдээллийг бодвол сониных уншигчдын ой тойнд илүү үлдэцтэй байдаг байна.

4. Популизм руу чиглэсэн хандлага

Солонгосын сонинууд чанартай, буурь суурьтай мэдээлэл, олны анхаарлыг татах хөнгөн мэдээ аль алиныг агуулж байдаг. Энэ нь сонинууд популист хүчин зүйлийг харгалзахын сацуу чанартай хэвлэл байх үүргээ умартадгүй гэсэн үг юм. Энэ хоёр элементийг хэрхэн зохистой хослуулах нь сонинуудын хувьд томоохон сорилт болоод байна. Бидэнд хоёр сонголт байна: Чанартай сонин болон шар сонины арифметик дундажийг барих уу, эсвэл сонины агуулгын чанар мэргэжилтнүүдээс өндөр үнэлгээ авсан байх, үүний зэрэгцээ спорт, хов жив, зугаа цэнгэл гэх мэт олонх хүмүүсийн сонирхдог мэдээ нийтлэлийг багтаах. Өнөөгийн байдлаар бид эхний хувилбарыг хэрэгжүүлж байгаа ч хоёр дахь хувилбарыг хэрэгжүүлэхийг зорьж байгаа билээ. Бид сониныхоо спорт, цэнгээнт булангаа уншигчдын сонирхолыг татахуйц болгохын зэрэгцээ соёл, нийгмийн амьдрал, шинжлэх ухаан, улс төр, эдийн засгийн асуудалд задлан шинжилгээ хийж, мэдээ, нийтлэл боловсруулахдаа өндөр стандартыг хангахыг зорьж байна. Солонгосын нийгмийн онцлогоос хамаараад Европ маягийн чанартай сонин манайд тохирохгүй. Зугаа цэнгээний болон чанартай мэдээ нийтлэлийн харьцаа 70-30 юм уу, 60-40 байх нь тохиромжтой гэж бид үзэж байгаа. Сонины нийтлэлийнхээ ихэнх хувийг их дээд сургууль төгссөн уншигчдад, мөн бага хувийг нь бага дунд боловсролтой бусад уншигчдад зориулж байгаа юм.

5. Уншигчдын тоог нэмэгдүүлэх

Чанартай, дүн шинжилгээ хийсэн мэдээ нийтлэл бүхий сонин мөнхөд захиалагчтай байсаар байх болно. Өнөө үед хүмүүс уншихад хялбар сонин илүүд үзэж байна. Тэгэхлээр сонины макет, загварын талаар судалгаа хийх нь чухал юм. Интернетийн харилцан мэдээлэл солилцох мөн чанарыг нь харгалзан хэвлэмэл мэдээллийн хэрэгслүүд уншигчидтайгаа харилцаа тогтоох шугамыг нээх ёстой. Сэтгүүлчдийн и-мэйл хаягаар уншигчдын санал хүсэлтийг хүлээж авах, зарим чухал асуудлаар интернет хэлэлцүүлэг явуулах зэрэг.

6. Нөлөөгөө нэмэгдүүлэх

Найдвартай байх нь хамгийн гол хүчин зүйл. Уншигчдын итгэл найдварыг хүлээхийн тулд бид мэдээ нийтлэл бичих, хянан тохиолдуулахад улс төр, бизнесийн хүрээний дарамт шахалтаас ангид байх ёстой. Мэдээлэл цаг үеэ олсон байх нь ихээхэн чухал байдаг.

Сек-Хюн Хон
Өмнөд Солонгосын
"Жун Ан Илбо" сонины дарга

Үргэлжлэл дараагийн дугаарт

Радио, телевиз, сонин хэвлэлийн ажилтнуудын мөрдөх ёс зүйн код /Швед улс/

Ёс зүйн кодыг Шведийн Хэвлэл мэдээллийн хамтын ажиллагааны Зөвлөл 1978 онд анх баталж, 1995 онд нэмэлт өөрчлөлт оруулсан байна. Тус Зөвлөлд Хэвлэн нийтлэгчдийн клуб, Шведийн сэтгүүлчдийн холбоо, Шведийн хэвлэн нийтлэгчдийн холбоо, Шведийн радио, Шведийн телевиз, Боловсролын радио, Радио өргөн нэвтрүүлгийн холбоо зэрэг байгууллага багтдаг.


Хэвлэл мэдээлэл болон радио, телевиз олон нийтийн эрх ашигт үйлчлэхийн тулд мэдээлэл түгээхдээ Үг хэлэх, Хэвлэн нийлэх эрх чөлөөний хуулийн хүрээнд л үйл ажиллагаа явуулах ёстой. Үүнтэй холбогдуулан хувь хүнийг хувийн амьдралын талаар хэвлэлд мэдээлснээр түүнд учрах зовлон зүдгүүрээс хамгаалах нь ихээхэн чухал ач холбогдолтой юм.

Мэргэжлийн ёс зүй гэдэгт тодорхой тооны дүрэм журмыг нэгмөсөн, эсвэл ганцхан удаа хэрэглэх бус харин сэтгүүлч хүн өөрийн мэргэжлийн хүрээнд хийж байгаа бүхэндээ байнга хариуцлага хүлээж байх ёстой. Ёс зүйн код нь телевиз, радио, хэвлэлийн ажилтнуудад ийм мэргэжлийн зан үйл бий болгох зорилготой байдаг.

1. ХЭВЛЭН НИЙТЛЭЛИЙН ДҮРЭМ

Мэдээллийн үнэн зөв байдлыг хангах

1. Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн нийгэмд гүйцэтгэх үүрэг нь олон нийтийн итгэх итгэлийг бий болгохын тулд үнэн зөв, олон талын мэдээлэл дамжуулахыг шаардаж байдаг.



2. Мэдээллийн эх сурвалжид шүүмжлэлтэй хандах хэрэгтэй. Нөхцөл байдал ямар байна, тэр хэмжээгээр мэдээллийг нарийн нягт шалгах, тэрчлэн урьд өмнө нь нийтэлсэн мэдээллийг ч гэсэн нягталж шалгах хэрэгтэй. Уншигч, сонсогчдод баримтыг тайлбараас ялгаж салгаж ойлгох боломж олгох.

3. Зарлал, толгой, зар мэдээ нь холбогдох

тексттэй байх ёстой.

4. Гэрэл зураг жинхэнэ эсэхийг шалгах. Тайлбар зураг, график нь үнэн зөв байхаас гадна эдгээрийг хүмүүсийг төөрөгдөлд оруулж болзошгүй далд санаатай байх ёсгүй.

Алдаагаа засахад бэлэн бай

5. Алдаа гаргасан нь нотлогдсон бол эхний шаардлагаар засч залруулна. Хэрэв тухайн хүн хангалттай үндэслэлээр тухайн мэдээллийг няцаах хүсэлтэй байвал түүнд үүнийг биелүүлэх боломж олгох хэрэгтэй. Мэдээллийг няцаасан, эсвэл залруулга хийснийг тухайн эх материалыг уншсан хүмүүс шууд анзаарахаар нийтэлнэ. Мэдээллийг няцаах тохиолдол бүрт редакцийн тайлбар шаардлагагүй гэдгийг тэмдэглэх нь зүйтэй.

6. Шведийн хэвлэлийн зөвлөлөөс танай сонин хэвлэлийг буруутгасан шийдвэр гаргасан бол үүнийг нэн даруй нийтлэх

Хүний хувийн халдашгүй байдлыг хүндэтгэ

7. Анхааралтай байх. Тухайн хүний амьдралтай холбоотой баримтыг нийтэлснээр түүний хувийн амьдралд зовлон учруулж болзошгүй. Зөвхөн олон нийтийн эрх ашгийн төлөө ийм алхам хийнэ.

8. Амиа хорлохыг завдсан, амиа өгүүтгэсэн тухай мэдээ материал нийтлэхдээ тун болгоомжтой хандах. Ийм мэдээ нийтлэл нь ойр дотны хүмүүсийн сэтгэлийг нь шархлуулж, түүний хувийн амьдралын эрхийг зөрчиж болзошгүй юм.

9. Золгүй явдал, гэмт хэргийн хохирогчийн талаар мэдээ материал бэлтгэхэд онцгой анхаарах хэрэгтэй. Мэдээ, нийтлэлд хохирогчийн нэрийг дурдаснаар хохирогч, түүний ойр дотных хүмүүст сэтгэл санааны ноцтой хохирол учруулж болзошгүй юм.

10. Тухайн хүний яс үндэс, арьс өнгө, мэргэжил, улс төр, шашин шүтлэг, бэлгийн зуршил зэрэгт онцгой анхаарал хандуулах хэрэггүй. Ийм зүйлийг зөвхөн мэдээ нийтлэлийн далд санаа, агуулгын хувьд зайлшгүй шаардлагатай гэж үзвэл авч үзэж болно.

Гэрэл зургийг нийтлэхдээ анхааралтай ханд

11. Дээр дурдсан дүрэм гэрэл зурагт ч гэсэн хамаарна.

12. Гэрэл зургийн эвлүүлэг, техникийн шинжтэй бусад өөрчлөлт нь уншигчдыг төөрөгдүүлж, буруу төсөөлөлтэй болгож болохгүй. Гэрэл зурагт холбогдох тайлбарыг зайлшгүй хавсаргах ёстой. Энэ нь архивын материалд ч гэсэн хамаатай.

Хоёр талын байр суурийг сонс

13. Шүүмжлүүлсэн хүнд хариу өгөх боломж олго. Зарим тохиолдолд шүүмжлэл нь шүүмжлэлд өртөж байгаа хүнийг сэтгэл санаагаар унагахад чиглэсэн байдаг гэдгийг анхаарах хэрэгтэй.

14. Эрүүгийн гэмт хэрэгт сэжиглэгдэж байгаа хүн гэм буруутай нь бүрэн нотлогдоогүй үед түүнийг хуулиар буруугүй гэж үздэг тухай санаж байх хэрэгтэй. Сонинд бичигдсэн хэргийн талаар дээд шатны шүүхээс гаргасан шийдвэрийн өөрчлөлтийг мэдээлэх хэрэгтэй.

Нэрийг дурдахдаа болгоомжтой бай

15. Тодорхой нөхцөлд тухайн хүний нэрийг нийтэлснээр тэр хүний амьдралд ямар үр дагавар учрахыг бодолц. Зөвхөн олон нийтийн эрх ашиг хөндөгдөх тохиолдолд нэрийг нь илчил.

16. Тухайн хүний нэрийг дурдахгүй гэж үзэж байгаа бол тухайн хүнийг хэн болохыг нь хэлж өгөх ямар ажил эрхэлдэг, албан тушаал, нас, хүйс, үндэс угсаа зэрэг мэдээлэл мөн гэрэл зургийг нь нийтлэхээс зайлсхий.

17. Тухайн хүний нэр, гэрэл зургийг нийтэлсэн хариуцлагыг энэ мэдээллийг түгээсэн хүн хүлээнэ гэдгийг ойлгох хэрэгтэй.


Тухайн хэрэг ОНМХ-тэй холбоотой бол "шударга сэтгүүл зүйн практик"-ийн үзэл баримтлалыг хэрхэн хэрэглэснийхээ төлөө Шведийн хэвлэлийн зөвлөл хариуцлага хүлээнэ. Уг асуудал нь ОНМХ-тэй холбоогүй бол үүнийг Омбудсмэн рүү шилждэг. Хэвлэлийн зөвлөл болон Омбудсмэн нь зөвхөн сонин хэвлэлийн асуудлыг хариуцдаг. Телевиз, радиотой холбоотой хэргийг Өргөн нэвтрүүлгийн комисс авч үздэг. Зөвлөлийн шийдвэрийг тухайн асуудалд холбогдсон сонин, "Хэвлэлийн сэтгүүл" болон "Сэтгүүлч" сэтгүүлд нийтэлдэг байна. Зөвлөлийн шийдвэрийн тухай тайлбарыг Шведийн хэвлэн нийтлэгчдийн холбооны төв хэвлэлд ч бас нийтэлдэг байна.



Далайд дусал

Хэвлэл мэдээлэл гуравдагч ертөнцийн хөгжлийн төлөө

Гуравдагч ертөнцийн өөрчлөлт, шинэчлэл дэх мэдээлэл харилцааны хандлага Нийгмийн маркетинг



1970-аад оныг хүртэл гэр бүл төлөвлөлт болон эрүүл мэндтэй холбоотой бусад салбарт идэвхтэй эх сурвалж, идэвхгүй хүлээн авагч гэсэн улиг болсон хэлбэр давамгайлж байсан. Зорилтот бүлэг мэдээлэл хүлээж авсан тохиолдолд үр дүн нь аяндаа бий болно гэсэн итгэлээр мэдээлэл харилцааны аянг зөвхөн нэг талын буюу дээрээсээ доошоо, мэдээллийг эх сурвалжаас хүлээн авагч руу гэсэн загварыг ашиглаж байсан /Рожерс 1973/. Үзэл бодлоороо тэргүүлэгчид, өөрчлөн шинэчлэгчид хүмүүсийг ятган ухуулах мэдээлэл дамжуулахдаа радио зэрэг олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдийг ашиглаж байжээ. Энэ стратегиар бол хүмүүс бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг сонгох, тэдгээрийг өөрсдийн амьдралд авч ашиглахад мэдлэг дутмаг байдаг. Энэхүү 1970-аад оны нийгмийн маркетингийн арга хэрэгсэлд мэдээлэл хүлээн авагчийн зан үйл, мэдлэг болон үнэт зүйлийг өөрчлөх томоохон зорилт тулгарч байгааг нийгэмд мэдрүүлсэн. Нийгмийн маркетинг гэсэн ойлголт анх 1971 онд гарч ирсэн бөгөөд үүнийг "бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг нийгэмд хүлээн авах талаар маркетингийн судалгаа, хуваарилалт, харилцаа холбоо, үнэ, төлөвлөлт зэрэгт нөлөөлөхүйцээр аливаа хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, үр дүнд хяналт тавих явдал гэж тодорхойлсон байдаг /Котлер болон Залтман 1971:5/. Харин өнөө үед нийгмийн маркетинг нь илүү өргөн хүрээтэй болсон бөгөөд үүнийг "хүмүүс болоод тэдний аж төрж буй нийгмийн сайн сайхныг улам сайжруулахын төлөө зорилтот бүлгийн зан байдалд нөлөөлөхөд чиглэсэн хөтөлбөрүүд боловсруулах, үнэлэх, хэрэгжүүлэх, төлөвлөх, дүн шинжилгээ хийхэд арилжааны маркетингийн технологи хэрэглэх" явдлыг хэлдэг болсон байна /Андерсон 1995:7/. Үзэл санаа, ажил үйлчилгээг нийтэд түгээн дэлгэрүүлэхэд нийгмийн маркетинг хэд хэдэн шинэ ойлголтыг бий болгосон юм. Үүнд: зорилтот бүлгээ тодорхойлох, маркетингийн судалгаа явуулах, бараа бүтээгдэхүүн шинээр бүтээх, хүмүүсийн анхаарлыг татан

урамшуулах, зорилтот бүлгийн хариу үйлдлийг дээд хэмжээнд хүргэх нөхцлийг бүрдүүлэх асуудлууд орж байна /Котлер 1984/.

Маркетингийн судалгаа гэдэг нь тусгайлсан нэг бараа бүтээгдэхүүн, үзэл санаа, ажил үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэхийн тулд тухайн зах зээл буюу хэрэглэгчээ нарийвчлан судлах, нийт хэрэглэгчдийн доторх тусгайлсан хэсэг бүлгүүд, тэдний мэдлэг болон зан байдлын онцлогууд, олон нийттэй харилцах кампанит ажлаар дамжуулан янз бүрийн хэсэг бүлгүүдэд нөлөөлөх, тэдэнд хүрэх ашиг-зарлагын дүн шинжилгээ хийх асуудал юм.

Бүтээгдэхүүн бий болгох гэдэг нь зөвхөн нэг бүтээгдэхүүн бий болгох бус зах зээлийн янз бүрийн сегментийн өөр өөр хэрэгцээнд зориулагдсан олон төрлийн бүтээгдэхүүн бий болгохыг хэлнэ. "Өөрөөр хэлбэл нийгмийн маркетер хүн боломж л байвал ганц бүтээгдэхүүнээ л борлуулах гэж чармайх бус /борлуулалтын арга барил/, харин зорилтот бүлгийн хэрэгцээнд нийцсэн шилдэг бүтээгдэхүүн боловсруулахын тулд ямагт судалгаа шинжилгээ хийж байх /маркетингийн арга барил/ хэрэгтэй" /Котлер 1984: 26/. Хүмүүсийн анхаарлыг татан урамшуулах гэдэг нь тухайн бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний хэрэглээг дээд хэмжээнд хүргэхийн тулд зорилтот бүлгийн хэрэглэгчдийг мөнгө болон сэтгэл зүйн талаас нь урвуулахыг хэлдэг. Зорилтот бүлгийн хариу үйлдлийг дээд хэмжээнд хүргэх нөхцлийг хангах гэдэг нь хэрэглэгчдийн зүгээс шинэ бараа бүтээгдэхүүнийг хүлээн авч хэрэглэхэд шаардлагатай цаг хугацаа эсвэл хүн чармайлтыг бууруулах замаар аливаа шинэлэг зүйлийг хүлээж авахыг хялбаршуулдаг.

Нийгмийн маркетер маркетингийн сүлжээн дэх 4P буюу бүтээгдэхүүн, үнэ, байршуулах, сурталчлах үйл явцыг бүхэлд нь иж бүрнээр авч үзэх ёстой. Нийгмийн маркетерүүдийн үндсэн ажил бол ОНМХ-ийг ашиглан байгууллагын зорилго болон бараа бүтээгдэхүүнийг олон нийтэд сурталчлан таниулах, тэд ямар бараа бүтээгдэхүүн олон нийтэд хэрэгтэй байгаа, ямар шагнал урамшуулал хамгийн зөв болох тараан хуваарилалтын ямар систем хамгийн тогтвортой болох, олон нийттэй харилцах ямар хөтөлбөр хамгийн үр дүнтэй болох талаар байгууллагадаа зөвлөгөө өгөх явдал болно.

Цагаа зүй зохистой зохицуулах 10 арга

1. Хийх ажлынхаа жагсаалтыг гарга. Ямар нэг ажил хийх тухай санаанд орсон даруйд нь тэмдэглэж авахын тулд орныхоо ойролцоох ширээн дээр тэмдэглэлийн дэвтрээ тавь.
2. Та ажил дээрээ ирсэн хойноо хийх ажлаа төлөвлөвөл хэтэрхий оройдсон гэж хэлж болно. Маргааш хийх ажлаа урд орой нь төлөвлө. Эн тэргүүнд хийх ажлынхаа цагийг тодорхой зааж өг.
3. Ажил дээрээ аль болох эрт ир. ...8:30-9:30-ийн хоорондох нэмэлт нэг цаг чинь тухайн өдрийн хоёр цагтай чинь тэнцэх хэмжээний үнэт цаг мөн. Эрт утасдвал хариу нь үдийн цайны цагаас чинь ч өмнө ирж мэднэ.
4. Ажил дээр цөөн хүн байгаа үеийг харгалзан сард 3 цаг ажил дээрээ өнгөрөө. Энэ хугацаанд өөрийгөө зохион байгуулж, тархиа амрааж, ширээгээ цэвэрлэн дараа долоо хоногийн юм уу, дараа сард амжуулах ажлаа төлөвлө.
5. Диктафон ашиглахаас аль болох зайлсхийх хэрэгтэй. Диктафоноос бичлэгээ буулгах гэж сэтгүүлчид ихээхэн цаг гарзлдаг. Ярилцлага авахдаа мөн мэдээ нийтлэл бэлтгэх явцад урт ишлэл авахаар бол диктафон ашиглавал тохиромжтой.



6. Зарим жижиг ажлыг орхигдуулахгүй бай. Зарим нэг жижиг ажлыг амжуулахад өдөрт 30 минут зарцуул. /эх сурвалжийг тэмдэглэх, уншигч руу утасдах, хувийн асуудлаар ч гэсэн утсаар ярьж болох юм/. Томоохон уулзалт, хүнээс ярилцлага авахаас 30 минутын өмнө энэ бүгдийг амжуул.
7. Хамгийн чухал ажилдаа ихэнх цагаа зарцуул. Энэ нь мэдээж мэт сонсдож магадгүй. Гэхдээ энэ нь мэдээнд юуг оруулах, юуг нь хасч сурахтай ижилхэн. Зарим сэтгүүлч, редакторууд үүнийг тэр болгон өөрийн болгож чаддаггүй.
8. Төсөвөө дуусахаас өмнө ажлаа бүтээ. Долоо хоногийн пүрэв гариг гэхэд дараа долоо хоногт юу хийхээ тогтоогоогүй бол танд асуудал үүснэ.
9. Ажлаа хийж дуусгах хувийн хугацаагаа тогтоо. Ямар нэг ажлыг пүрэв гаригийн 5 цагт хийж дуусгах ёстой бол үүнийгээ тэр өдрийн 2 цагт хийж дуусгахыг чармай. Ингэснээр та сэтгэл хангалуун байх болно.
10. Хэзээ ажил дээрээ удаан сууж, хэзээ явахаа сайн мэддэг байх хэрэгтэй. Долоо хоногт 60 цаг ажилласны төлөө редакц чинь таныг одонгоор шагнахгүй. Ажил ихтэй үед олон цагаар эрчимтэй ажилла. Ажлаасаа эрт явахдаа сэтгэл зовох хэрэггүй.

Бэлтгэсэн: Г.Нарангараа